

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК

АУДИТЫН КОД: СТА-ХК-24/18
2024 ОНЫ 12 САРЫН 31

Агуулга

1. Аудитын тайлан дүгнэлт хүргүүлэх тухай
2. Хараат бус аудиторын тайлан, дүгнэлт
3. Аудитлагдсан санхүүгийн тайлан
4. Оршил
5. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага
6. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт
7. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин
8. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ
9. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал
10. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар
11. Аудитын явцад хийсэн залруулга, алдаа зөрчлийн талаарх мэдээлэл
12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Үйл ажиллагааны орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга
14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналийн олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НБЁЗОУСЗ	Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



УБ хот, БЗД, 6-р хороо, Эрхэт оффис, 902 тоот,
Утас: 11-450-410, 99077062, 99125283
И-мэйл: ikhnayadaudit@gmail.com

2025.08.25 № СТА-ХК-24/18

Г ЭРДЭНЭТ ХҮНС ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Р.МӨНГӨНШАГАЙ ТАНАА

Г

Г Аудитын тайлан, дүгнэлт хүргүүлэх тухай Г

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК болон “ИХ НАЯД АУДИТ” ХХК-ийн хооронд байгуулсан санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний гэрээ /хэлцэл/-г үндэслэн “ЭРДЭНЭТ ХҮНС” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн тайланг шалгаж санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүллээ.

Энэхүү аудитын тайлан, дүгнэлттэй танилцаж, эдгээртэй холбоотой асууж тодруулах зүйл байвал бид тайлбарын хамт санал бодлоо хуваалцахад бэлэн байна.

Хүндэтгэсэн



ЗАХИРАЛ

Х.АРИУНЗУЛ

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу “ЭРДЭНЭТ ХҮНС” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудад аудит хийлээ.

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын холбогдох хууль, журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлтөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

“ИХ НАЯД АУДИТ” ХХК



Х.АРИУНЗУЛ

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2025 оны 08 сарын 25

"ЭРДЭНЭТ ХҮНС" ХК

БАЛАНС

2024 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	314,005,291.66	270,850,964.85
Дансны авлага	124,545,454.55	124,545,454.55
Татвар, НДШ-ийн авлага	-	-
Бусад авлага	11,194,800.00	11,194,800.00
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	74,552,434.47	112,517,713.39
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
Бусад үндсэн хөрөнгө	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	524,297,980.68	519,108,932.79
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	662,672,386.00	626,749,450.00
Биет бус хөрөнгө	-	-
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	662,672,386.00	626,749,450.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,186,970,366.68	1,145,858,382.79

"ЭРДЭНЭТ ХҮНС" ХК

	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	-	-
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	104,951,174.07	98,901,926.18
НДШ-ийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	-	-
Хүүний өглөг	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж олсон орлого	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-
Богино хугацаат өр төлбөр	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	104,951,174.07	98,901,926.18
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	104,951,174.07	98,901,926.18
Эзэмшигчийн өмч		
-төрийн	-	-
- хувийн	887,073,400.00	887,073,400.00
- хувьцаат	-	-
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмч бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг	194,945,792.61	159,883,056.61
Эздийн өмчийн дүн	1,082,019,192.61	1,046,956,456.61
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,186,970,366.68	1,145,858,382.79

"ЭРДЭНЭТ ХҮНС" ХК

ОРЛОГЫН ТАЙЛАН 2024 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	54,545,454.55	6,727,273.00
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг /алдагдал/	54,545,454.55	6,727,273.00
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	-	-
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	41,767,558.22	39,880,918.00
Ерөнхий ба удирдлагын зардал	6,000.00	-
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	12,771,896.33	(33,153,645.00)
Орлогын татварын зардал	127,718.97	-
Татварын дараах ашиг (алдагдал)	12,644,177.36	(33,153,645.00)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	12,644,177.36	(33,153,645.00)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	12,644,177.36	(33,153,645.00)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

"ЭРДЭНЭТ ХҮНС" ХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2024 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31 үлдэгдэл	887,073,400.00	-	-	-	-	194,945,792.61	1,082,019,192.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-	-
Залруулсан үлдэгдэл	887,073,400.00	-	-	-	-	194,945,792.61	1,082,019,192.61
Тайлант үеийн цэвэр ашиг						(33,153,645.00)	(33,153,645.00)
Бусад дэлгэрэнгүй орлого							
Өмчид гарсан өөрчлөлт							-
Зарласан ногдол ашиг							
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						(1,909,091.00)	(1,909,091.00)
2024 оны 12 сарын 31 үлдэгдэл	887,073,400.00	-	-	-	-	159,883,056.61	1,046,956,456.61

"ЭРДЭНЭТ ХҮНС" ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2024 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	7,400,000.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	6,200,000.00
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	-	1,200,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	42,764,408.34	50,554,326.81
Ажилчдад төлсөн	-	-
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	-
Бараа материал худалдан авахад төлсөн	41,756,008.34	41,749,526.81
Ашиглалтын зардалд төлсөн	-	-
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	300,000.00
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	500,000.00	2,398,000.00
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	508,400.00	6,106,800.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(42,764,408.34)	(43,154,326.81)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-

"ЭРДЭНЭТ ХҮНС" ХК

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн

Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Ханшийн зөрүү	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Валютын ханшийн алдагдал	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(42,764,408.34)	(43,154,326.81)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	356,769,700.00	314,005,291.66
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	314,005,291.66	270,850,964.85

Аудитын тайлан

1. Оршил

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК (цаашид үйлчлүүлэгч гэх)-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг үйлчлүүлэгч компанийн Гүйцэтгэх захирал **Р.МӨНГӨНШАГАЙ** танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Мөн аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу үйлчлүүлэгч болон “ИХ НАЯД АУДИТ” ХХК -ийн хооронд байгуулсан санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний гэрээ /хэлцэл/-г үндэслэн “ЭРДЭНЭТ ХҮНС” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн тайланг шалгаж аудит хийлээ.

Үйлчлүүлэгчийн 2024 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Үйлчлүүлэгчийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг “ИХ НАЯД АУДИТ” ХХК-ийн чанарын хяналтын менежер **Х.Ариунзул** чанарын хяналтыг хийж, аудитор **Х.Ариунтуяа**, туслах аудитор **Т.Энхжаргал** нар хариуцаж хэрэгжүүлэв.

3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан “ИХ НАЯД АУДИТ” ХХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Аудитын тухай хууль болон санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Аудитын тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК-ийн талаарх ерөнхий мэдээлэл:

- ❖ Регистрийн дугаар: **2030756**
- ❖ Үйл ажиллагааны чиглэл: **Талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа, Ундаа, цэвэр усны үйлдвэрлэл, Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, Архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, Гадаад, дотоод худалдаа зуучлал,**
- ❖ Харилцдаг санхүү, татварын байгууллага: **Орхон аймгийн татвар болон төрийн сангийн хэлтэс**
- ❖ Гүцэтгэх захирал: **Рэнчээ Мөнгөншагай**
- ❖ ТУЗ-ын дарга: **Дэржээ Цэвээнжав**
- ❖ Ерөнхий нягтлан бодогчийн нэр:
- ❖ Хаяг: **Орхон аймаг, Баян-Өндөр сум, 13-р баг, Баянцагаан, “Эрдэнэт хүнс”**
- ❖ Санхүүгийн тайлан хүргүүлж ирсэн огноо: **2025.08.17**

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Үндсэн хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Аудитын тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Холбогдох бусад хууль.

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үйлчлүүлэгч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үйлчлүүлэгч байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад үйлчлүүлэгч байгууллагын санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АОУС-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн хэмжээг сонгов.

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК-ийн 2024 оны нийт хөрөнгө **1,145,858.4** мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох **11,458.6** мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь уламжлалт болон хяналтын эрсдлийг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

8. Аудитын явцад хийсэн залруулга, алдаа зөрчлийн талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын залруулсан алдаа болон шийдвэрлэсэн зөрчилтэй асуудал ажиглагдаагүй болно.

9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудалгүй байна.

10. Үйл ажиллагааны орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК нь тайлант хугацаанд нийт **6,727.3** мянган төгрөгийн борлуулалтын орлоготой, борлуулалтын өртөггүй ажиллаж, **39,880.9** мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гарч, **33,153.6** мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

11. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид **“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК**-ийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын дүгнэлтэд тодорхой дурдав.

Аудиторын дүгнэлт гаргахдаа үйлчлүүлэгч байгууллагын бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

Санхүүгийн тайланг шалгасан:

“ИХ НАЯД АУДИТ” ХХК-ийн

Аудитор:

..... / **Х.Ариунтуяа** /

Аудиторын туслах:

..... / **Т.Энхжаргал** /

Утас: +976 9907-7062, 9912-5283

И-мэйл: ikhnayadaudit@gmail.com

Үйлчлүүлэгч байгууллага:

“ЭРДЭНЭТ ХҮНС” ХК-ийн

Захирал:

..... / **Р.Мөнгөншагай** /

Нягтлан бодогч:

..... /

Утас: +976 9910-6926

И-мэйл: shagairenchee@gmail.com